# МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМД ОЮУ ТОЛГОЙ ХХК-ИЙН ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР

Оюу толгой ХХК-д зориулан бэлтгэв.

Улаанбаатар
2026 он

# Агуулга


**01**
Монгол Улсын эдийн засагт Оюу толгой ХХК-ийн оруулж буй хувь нэмэр

**02**
Монгол Улсын нэгдсэн төсөвт Оюу толгой ХХК-ийн оруулж буй хувь нэмэр

**03**
Монгол Улсын нийгэмд Оюу толгой ХХК-ийн оруулж буй хувь нэмэр

**04**
Судалгааны онол арга зүйн үндэслэл, тооцооллын аргачлал




# 01

## Монгол Улсын эдийн засагт Оюу толгой ХХК-ийн оруулж буй хувь нэмэр

ISO 20252 CERTIFIED RESEARCH STANDARD
ESOMAR 25 Corporate




1. Нэмүү үнэ цэнийг бий болгож, ДНБ-д шууд хувь нэмрээ оруулж...

2. Үржүүлэгчийн нөлөө үзүүлж нэмэлт эрэлтийг үүсгэж...

3. Эдийн засгийн өсөлтийг дэмжиж...

4. Нэг хүнд ногдох ДНБ-д хувь нэмрээ оруулж, эдийн засгийн өсөлтийг иргэдэд хүргэж...

5. Хөрөнгө оруулалт, түүн дотроо гадаадын шууд хөрөнгө оруулалтыг хийж...

6. Цэвэр экспортын дүнгээр гадаад худалдааны тэнцэлд эерэг нөлөө үзүүлж...

7. Хөрөнгө оруулалт, экспорт хийж гадаад валютын нөөцийг бүрдүүлж, ханшийг тогтворжуулж...

8. Үндэсний ханган нийлүүлэгчдийг дэмжиж дотоодын эдийн засагт хувь нэмрээ оруулж...

9. Татвар, хураамжийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэн...

10. Орон нутгийн дэд бүтэц, нийгмийн салбаруудад хөрөнгө оруулалт хийж...

# Монгол Улсын ДНБ-д Оюу толгой ХХК-ийн оруулж буй хувь нэмэр

## Монгол Улсын ДНБ-д Оюу толгой ХХК-ийн оруулсан хувь нэмэр, оны үнээр, их наяд төгрөгөөр




### Монгол Улсын ДНБ

2010 он




**9.8** их наяд төгрөг

x **8.3** дахин тэлсэн

2024 он




**80.7** их наяд төгрөг

### Оюу толгой ХХК-ийн бий болгосон нэмүү үнэ цэнэ

2010-2024 он хүртэлх 15 жилийн хугацаанд




**65.8** их наяд төгрөг

OT/MNG **12.9** %




**512.2** их наяд төгрөг

" **15** жилийн хугацаанд Оюу толгой ХХК Монгол Улсын **2** жилийн ДНБ-ийг дангаараа бүрдүүлжээ. "

Жилийн дундаж

**34.1** их наяд төгрөг

2010 он




**0.9** их наяд төгрөг

x **5.2** дахин өссөн

2024 он




**4.7** их наяд төгрөг

# Монгол Улсын ДНБ-д Оюу толгой ХХК-ийн оруулсан хувь нэмэр

## Монгол Улсын ДНБ-д Оюу толгой ХХК-ийн бий болгосон нэмүү үнэ цэний эзлэх хувь, %




**Хөрөнгө оруулалтын шинэ мөчлөгийн эхлэл**

- Гүний уурхайн бүтээн байгуулалтыг сэргээн эхлүүлж, 5.3 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр шийдвэрлэв.
- Хоёрдугаар шатны бүтээн байгуулалт эхэлсэн.
- "Итгэл сэргээсэн эргэлтийн цэг"

**Гүний уурхай 2023 онд бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхэлснээр Оюу толгой компани Монгол Улсын ДНБ-ий 8-12%-ийг бүрдүүлэхээр болж байна.**

**Хөрөнгө оруулалтаас үйлдвэрлэлд шилжиж, бодит өгөөжөө өгч эхэлсэн үе**

- Блокчлон олборлох технологийг ашиглан 21 дэх хүдэр буулгуурын тэсэлгээг хийснээр, гүний уурхайн олборлолтыг эхлэв. (2023.03.13).
- Агааржуулалтын босоо амны нэвтрэлт 1000 метрт хүрч, Гүний уурхайн үйлдвэрлэл бүрэн хүчин чадалдаа хүрч, бүтээн байгуулалтын үе шат өндөрлөхөд түлхэц болсон (2024.02.14).

**"Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн хөдөлгүүр"**

- Хөрөнгө оруулалтын гэрээ хэрэгжиж эхэлж, баяжуулах үйлдвэрийг барьж эхэлсэн.
- Монгол Улсын эдийн засаг 2011 онд дэлхий дээрх хамгийн өндөр өсөлттэй эдийн засгуудын нэг болж, 17.3%-ийн өсөлттэй байсан.
- Энэхүү өндөр өсөлт нь Оюу толгой ХХК-ийн хөрөнгө оруулалттай холбоотойгоор бий болсон.

**"Эдийн засгийн тогтвортой байдлын тулгуур – Экспорт, валютын урсгалыг үүсгэгч"**

- Оюу толгой ХХК зэсийн баяжмал үйлдвэрлэж эхэлж, 2013 оны 7 дугаар сард анхны 576 тонн зэсийн баяжмалыг экспортод гаргасан.
- Оюу толгой төслийн эхний жил (2013 он)-д 290 мянган тонн зэсийн баяжмал үйлдвэрлэсэн.
- Гүний уурхайн бүтээн байгуулалтын төлөвлөгөө, санхүүжилтийн гэрээг батлав (2015 он).

**Урт хугацааны суурийг бэхжүүлсэн бүтээн байгуулалтын үе – Гүний уурхайн болон орон нутгийн хамтын ажиллагааны хөрөнгө оруулалтын үе**

- Гүний уурхайн захиргаа үйлчилгээний Чандмань төв нээгдэв (2019.08 сар), үйлдвэрлэлийн амны бүтээн байгуулалтыг дуусгав (2019.12 сар). Гүний уурхайн хүдэр буулгуурын анхны тэсэлгээг амжилттай хийсэн (2022.06 сар).
- Ханбогд суманд Цэвэр ус хангамжийн цогцолборыг ашиглалтад оруулав (2017.04 сар). 640 хүүхдийн суудалтай сургууль, 200 хүүхдийн ортой цэцэрлэгийг бариулж иж бүрэн тохижуулж хүлээлгэн өгөв (2018.05 сар). Ханбогд сумын хөгжилд зориулан 50 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр шийдвэрлэв (2022.05 сар).

**Тайлбар:** 2010-2024 оны хооронд хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, тэдгээрийг санхүүгийн бүртгэлд бүртгэж буй байдлаас шалтгаалан Оюу толгой компанийн бий болгосон нэмүү цэн энэ хугацаанд харилцан адилгүй, хэлбэлзэлтэй байжээ. Мөн нягтлан бодох бүртгэлийн стандарт болон үндэсний тооцооны системийн зарчмын зөрүү энд нөлөөлж байна.

# Монгол Улсын 2024 оны ДНБ-д үзүүлсэн нийт нөлөө буюу үржүүлэгчийн нөлөө

**Оюу толгой ХХК-ийн нэмүү үнэ цэний шууд бус үржүүлэгч 0.296 байгаа нь:**

Оюу толгой ХХК 2024 онд үндэсний ханган нийлүүлэгч 642 аж ахуйн нэгжээс 3.1 их наяд төгрөгийн худалдан авалт хийснээр тэдгээр ханган нийлүүлэгчид Монгол Улсын эдийн засагт 1.4 их наяд төгрөгийн нэмүү үнэ цэнийг бий болгожээ. Оюу толгой ХХК 1 тэрбум төгрөгийн нэмүү үнэ цэнийг бий болгосноор түүнийг дагаад үндэсний ханган нийлүүлэгчид 295.8 сая төгрөгийн нэмүү үнэ цэнийг болгож байгааг харуулж байна. Энэ бол эдийн засагт үзүүлж буй "эхний давлагаа"-ны буюу шууд бус нөлөө юм.

**Оюу толгой ХХК-ийн нэмүү үнэ цэний өдөөгдсөн нөлөө 0.326 байгаа нь:**

Оюу толгой ХХК-ийн 4.7 мянган ажиллагчид, үндэсний ханган нийлүүлэгч 642 аж ахуйн нэгжийн ажиллагчдын цалингийн орлого Монгол Улс, орон нутгийн эдийн засагт 1.5 их наяд төгрөгийн нэмүү үнэ цэнийг бий болгожээ. Энэ нь Оюу толгой ХХК 1 тэрбум төгрөгийн нэмүү үнэ цэнийг бий болгосноор үндэсний болон орон нутгийн эдийн засагт 325.6 сая төгрөгийн нэмүү үнэ цэний эрэлт болгож байгааг харуулж байна. Энэ бол эдийн засагт үзүүлж буй "хоёр дахь давлагаа"-ны буюу өдөөгдсөн нөлөө юм. Цалин хөлс болон ажиллагчдын нийгмийн хангамж өндөр байх тусам энэ нөлөө нэмэгддэг.

**Оюу толгой ХХК-ийн нэмүү үнэ цэний нийт үржүүлэгч 1.623 байгаа нь:**

Оюу толгой ХХК-ийн бий болгосон 1 тэрбум төгрөгийн нэмүү үнэ цэн нь эдийн засагт нэмэлтээр 623 сая төгрөгийн нэмүү үнэ цэнийг бий болгожээ. Оюу толгой ХХК 2024 онд 4.7 их наяд төгрөгийн нэмүү үнэ цэнийг шууд бий болгож, нийт үржүүлэгчийн нөлөөгөөр Монгол Улсын эдийн засагт нийтдээ 7.6 их наяд төгрөгийн нэмүү үнэ цэнийг бий болгосон нь Монгол Улсын ДНБ-ий 9.4%-ийг эзэлж байна.




**Өдөөгдсөн үржүүлэгчийн нөлөө:**

Оюу толгой ХХК болон ханган нийлүүлэгчдийн ажиллагчдын орлогоос бий болсон хэрэглээнээс үүсэх эдийн засгийн үр нөлөө буюу нэмүү үнэ цэн.

**Шууд бус үржүүлэгчийн нөлөө:**

Нийлүүлэлтийн сүлжээний хүрээнд бий болсон нийлүүлэгчид, тээвэрлэгч, туслан гүйцэтгэгчдийн бий болгосон нэмүү үнэ цэн.

**Шууд үржүүлэгчийн нөлөө:**

Үйлдвэрийн үйл ажиллагаанаас ДНБ-д шууд оруулж буй хувь нэмэр буюу бүтээгдэхүүн, үйлчилгээгээр бий болсон ашиг, цалин, татвар зэрэг шууд нэмүү үнэ цэн.

## Давлагаалсан нөлөө (RIPPLE EFFECT)

**Улс орнуудын уул уурхайн салбарын ДНБ-ий үржүүлэгч**

| | Монгол* | Канад** |
|---|---|---|
| Шууд нөлөө | 1.065↗ | 1.189↗ |
| Шууд бус нөлөө | 0.464↗ | 0.411↗ |
| Өдөөгдсөн нөлөө | 0.218↘ | 0.018↘ |
| Нийт нөлөө | 1.747↗ | 1.617↘ |

Тайлбар: ↗ Оюу толгой компанийн үзүүлэлтээс их,
↘ Оюу толгой компанийн үзүүлэлтээс бага,
= Оюу толгой компанийн үзүүлэлттэй тэнцүү.

**Үржүүлэгчийн нийт нөлөө:**

Шууд + шууд бус + өдөөгдсөн

Эх сурвалж: * Салбар хоорондын тэнцэл, ҮСХ, 2019 он,
** Канадын статистикийн газар 2022 он, https://www150.statcan.gc.ca/

# Монгол Улсын ДНБ-д үзүүлж буй үржүүлэгчийн нөлөө

**Оюу толгой ХХК-ийн Монгол Улсын эдийн засагт үзүүлэх үржүүлэгчийн нөлөө, коэффициентоор**




2015 онд

Оюу толгой ХХК-ийн 1 тэрбум төгрөгийн үйлдвэрлэл



Монгол Улсын эдийн засагт **261.3 сая төгрөгийн эрэлтийг нэмэлтээр бий болгож байсан** бол..

2024 онд



Үржүүлэгчийн нөлөө

x**2.4**

Үржүүлэгчийн нөлөөгөөр бий болсон **нэмэлт эрэлт 623.4 сая төгрөг болж, 2.4 дахин нэмэгджээ.** Үүний дотор шууд бус нөлөөний үржүүлэгч 2.0 дахин нэмэгдсэн бол өдөөгдсөн нөлөөний үржүүлэгч 3.0 дахин нэмэгджээ.

**Монгол Улсын ДНБ-д Оюу толгой ХХК-ийн үржүүлэгчийн нөлөөгөөр бий болсон нэмүү үнэ цэнийн эзлэх хувь**




Үржүүлэгчийн нөлөөгөөр Оюу толгой ХХК

- 2016 онд Монгол Улсын эдийн засгийн 1/3-ийг бүрдүүлж байсан бол...
- 2022 онд гүний уурхайг ашиглалтад оруулснаар Монгол Улсын эдийн засгийн тал хувийг бүрдүүлжээ.
- 2023 оноос хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил дууссанаар үйлдвэрлэлийн хэмжээ тогтворжиж, Монгол Улсын эдийн 9.4%-9.7%-ийг эзлэх болжээ.

# Эдийн засгийн өсөлтөд үзүүлсэн нөлөө



- **Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2011 онд 17.3%-д хүрч**, дэлхийд эдийн засгийн өсөлтөөрөө тэргүүлэгч улс болоход **уг өсөлтийн 13.5%-ийн өсөлтийг Оюу толгой ХХК бий болгожээ.** Хэрэв “Оюу толгой ХХК байгаагүй бол” эдийн засгийн өсөлт тухайн онд 3.8% болох байжээ.
- Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ, эрэлт буурч, макро эдийн засгийн, түүн дотроо төсөв санхүүгийн тогтворгүй байдал үүсэж эдийн засгийн өсөлт суларсан **2016 онд Оюу толгой ХХК-ийн Гүний уурхайн хөрөнгө оруулалт шийдэгдэж, бүтээн байгуулалтыг эхлүүлснээр эдийн засгийн уналтын мөчлөгийг сэрж, эдийн буурал бус өсөлтийг бий болгожээ.** Оюу толгойн **Гүний уурхайн хөрөнгө оруулалт эдийн засгийн өсөлт, тогтворжилтын эргэлтийн цэг болсон.**
- Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ эрген сэргэсэн, Гүний уурхайн бүтээн байгуулалтын ажил эрчимжсэнээр **2018 онд Оюу толгой ХХК эдийн засгийн өсөлтийн хурдасгуурын үүргээ дахин гүйцэтгэсэн.**
- Гүний уурхайн бүтээн байгуулалтын ажил 2022 онд дуусаж, **2023 онд гүний уурхайн олборлолтыг эхлүүлснээр Оюу толгой ХХК Монгол Улсын эдийн засгийн өсөлтөд тогтвортой хувь нэмрээ оруулах нөхцөл бүрджээ.**



# Монгол Улсын нэг хүнд ногдох ДНБ-д үзүүлсэн нөлөө

Монгол Улсын нэг хүнд ногдох ДНБ-д Оюу толгой ХХК-ийн оруулсан хувь нэмэр, ам.доллароор




2021-2024 онд Оюу толгой ХХК нь Монгол Улсын нэг хүнд ногдох ДНБ-д жилд дундажаар 770 ам.долларыг бий болгожээ. Ийнхүү Монгол Улсыг дундаас дээгүүр орлоготой улс орон болон дэвшихэд Оюу толгой ХХК өөрийн хувь нэмрийг оруулжээ.

WORLD BANK GROUP

**Дэлхийн банк**: Улс орнуудын орлогын ангиллын түвшин

| | Low income | Lower-middle income | Upper-middle income | High income |
|---|---|---|---|---|
| July 1, 2023 – for FY24 (new) | <=1,135 | 1,136-4,465 | 4,466-13,845 | >13,845 |
| July 1, 2022 – for FY23 (previous) | <=1,085 | 1,086-4,255 | 4,256-13,205 | >13,205 |

Эх сурвалж: https://blogs.worldbank.org/en/opendata/new-world-bank-group-country-classifications-income-level-fy24

# Монгол Улсын нийт болон гадаадын хөрөнгө оруулалтын дунд эзлэх хувь

**Монгол Улсын нийт хөрөнгө оруулалт, гадаадын хөрөнгө оруулалт болон Оюу толгой ХХК-ийн хөрөнгө оруулалт, их наяд төгрөгөөр**

Оюу толгой ХХК Монгол Улсад 2010-2024 оны хоорондох 15 жилийн хугацаанд **44.7 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.**




**Монгол Улсын нийт болон гадаадын хөрөнгө оруулалтад Оюу толгой ХХК-ийн эзлэх хувь**

Энэ хугацааны:
- Нийт хөрөнгө оруулалтын **21.0%**
- Гадаадын хөрөнгө оруулалтын **35.1%**



# Монгол Улсын экспорт, импортод эзлэх хувь

Оюу толгой ХХК-ийн экспортын дүн болон МУ-ын нийт экспортод эзлэх хувь, сая ам.доллар болон %




- Оюу толгой ХХК 2013-2024 оны хооронд нийтдээ 18.9 тэрбум ам.долларын экспорт хийсэн нь Монгол Улсын нийт экспортын 18.7%-ийг эзэлж байна.
- 2014-2016 онд Оюу толгой ХХК-ийн экспорт нийт экспортод 30-40%-ийг эзэлж байжээ.
- Монгол Улсын нүүрсний экспорт 2017 оноос нэмэгдсэнээр Оюу толгой ХХК-ийн экспорт нийт экспортод 10-20%-ийг эзлэх болжээ.
- Оюу толгой ХХК 2024 оны байдлаар Монгол Улсын нийт экспортын 15.5%-ийг бүрдүүлжээ.

Оюу толгой ХХК-ийн импортын дүн болон МУ-ын нийт импортод эзлэх хувь, сая ам.доллар болон %




- Оюу толгой ХХК 2010-2024 оны хооронд нийтдээ 3.5 тэрбум ам.долларын импорт хийсэн нь Монгол Улсын нийт импортын 3.8%-ийг эзэлж байна.
- Оюу толгой ХХК-ийн хөрөнгө оруулалт 2010-2012 онд голлон хийгдэж, 1.5 тэрбум ам.долларын импорт хийсэн нь Монгол Улсын нийт импортод 9.3%-ийг эзэлж байжээ.
- Монгол Улсын нийт импортод Оюу толгой ХХК-ийн импортын эзлэх хувь 2013-2020 онд 4.5-3.1% болж буурч, улмаар дотоодын ханган нийлүүлэгчидтэй хамтран ажиллах болсноор 2021 оноос 1.5-1.0% болж буурчээ.
- Оюу толгой ХХК 2024 оны байдлаар Монгол Улсын нийт импортын 1.0%-ийг бүрдүүлжээ.

# Монгол Улсын гадаад худалдааны тэнцлийн ашгийг бүрдүүлсэн байдал

**Монгол Улсын гадаад худалдааны тэнцлийн ашигт Оюу толгой ХХК-ийн цэвэр экспортын эзлэх хувь, %**




- Гадаад худалдааны "зүтгүүр – хөдөлгүүр (локомотив)"
- Монгол Улсын гадаад худалдааны "тулгуур багана"

## 2014-2024



**1.7** тэрбум ам.доллар **импорт***

Олборлолт - Үйлдвэрлэлт

**18.7** тэрбум ам.доллар **экспорт**

**Оюу толгой ХХК-ийн экспорт, импортын* харьцаа**




## 2014-2024



**1 USD Импорт***

Олборлолт - Үйлдвэрлэлт

**11 USD экспорт**

**Тайлбар:** * - Энд зөвхөн Оюу толгой компанийн өөрийн хийсэн импортын үнийн дүнгээр тооцсон бөгөөд ханган нийлүүлэгчдээс авсан импортын үнийн дүн ороогүй болно.

# Гадаад валютын нөөц бүрдүүлэлтэд үзүүлсэн нөлөө

**Оюу толгой ХХК-ийн Монгол Улсад оруулж ирсэн гадаад валютын хэмжээ**

2010-2024 оны хооронд

**15**

жилийн хугацаанд

Монгол Улсад

**19.2**

тэрбум ам.доллар оруулжээ

- Оюу толгой ХХК 2010-2024 оны хооронд нийтдээ 19.2 тэрбум ам.долларыг Монгол Улсад оруулж иржээ.
- Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2012 оны 12-р сард анх удаа 4.1 тэрбум ам.долларт хүрсэн нь Оюу толгой ХХК-ийн 2011-2012 онд хийсэн хөрөнгө оруулалтын нөлөө байжээ.
- Оюу толгой ХХК-ийн оруулж ирсэн гадаадын валютын хэмжээ буурсан 2014-2016 (гүний уурхайн бүтээн байгуулалт зогссон байсан үе) оны хооронд Монгол Улсын гадаад валютын нөөцийн хэмжээ мөн 1.6-1.3 тэрбум ам.доллар болж буурч байжээ.
- Тухайн жил бүрийн Монгол Улсын сарын дундаж импортын дүнтэй харьцуулахад Оюу толгой ХХК-ийн оруулж ирсэн гадаад валютын хэмжээ дунджаар Монгол Улсын 2.5 сарын импортыг хангах боломжтой байжээ.

**Монгол Улсын гадаад валютын албан нөөц болон Оюу толгой ХХК-ийн оруулж ирсэн гадаад валютын хэмжээ, сая ам.доллар**



# Гадаад валютын ханшид үзүүлсэн нөлөө

- 2010-2016 оны хооронд Оюу толгой компанийн гадаад валютын урсгал нэмэгдэхэд төгрөгийн ам.долларын эсрэг ханш чангарч, Оюу толгой компанийн гадаад валютын орох урсгал буурахад төгрөгийн ам.долларын эсрэг ханш суларч байжээ.
- 2017 оноос нүүрсний үнэ, экспортын хэмжээ нэмэгдэж, улсын төсвийн орлого нэмэгдэж, нөгөө талдаа импортын хэмжээ нэмэгдсэн. Эдийн засаг ч мөн энэ хэмжээгээр тэлж, гадаад валютын гадагшлах урсгал нэмэгдсэн.

Оюу толгой ХХК-ийн Монгол Улсад оруулж ирсэн гадаад валютын хэмжээ, сая ам.доллар




Ам.долларын жилийн дундаж ханш, төгрөгөөр



# Оюу толгой ХХК-ийн худалдан авалт

Үндэсний ханган нийлүүлэгчдээс авсан бараа, үйлчилгээний болон импортын дүнгийн харьцуулалт

2010-2024 оны хооронд

**15**

жилийн хугацаанд

Үндэсний 9,366 ханган нийлүүлэгчээс*

**17.3** буюу **6.6**

их наяд төгрөг / тэрбум ам.доллар

бараа, үйлчилгээ худалдан авчээ

ам.доллароор:
1.9 дахин их

**>**

төгрөгөөр:
2.5 дахин их

Импортоор

**3.5** буюу **6.8**

тэрбум ам.доллар / их наяд төгрөг

бараа худалдан авчээ

* Тайлбар: давтагдсан тоогоор

Үндэсний ханган нийлүүлэгчдээс авсан бараа, үйлчилгээний болон импортын дүн, сая ам.доллар



# Оюу толгой ХХК-ийн дотоодын худалдан авалт

- 2010-2024 онд Оюу толгой ХХК-ийн төлсөн дотоодын бараа, үйлчилгээний татвар энэ төрлийн татварын орлогын 21%-ийг эзэлж байна.
- Энэ нь Оюу толгой ХХК дотоодын бараа, үйлчилгээний хамгийн том худалдан авагчдын нэг болж, дотоодын бараа, ажил үйлчилгээний эргэлтийн 1/5-ийг бүрдүүлж байгааг харуулж байна.
- Оюу толгой ХХК-ийн худалдан авалт 2012, 2018 онуудад дотоодын бараа, үйлчилгээний эргэлтийн 1/3-ийг бүрдүүлж байжээ.

**Монгол Улсын дотоодын бараа, үйлчилгээнээс төвлөрсөн татварын орлогод Оюу толгой ХХК-ийн эзлэх хувь**




**Оюу толгой ХХК-тай хамтран ажилладаг үндэсний ханган нийлүүлэгч аж ахуйн нэгжийн тоо**



# Оюу толгой ХХК-ийн орон нутгийн бизнесийн идэвхжилд үзүүлсэн нөлөө

- 2013 онд Өмнөговь аймгийн Ханбогд сумын 1,000 хүн амд үйл ажиллагаа явуулж байгаа 15 аж ахуйн нэгж, байгууллага (ААНБ) ногдож байсан бол 2024 онд энэ үзүүлэлт 43 болж, бизнесийн идэвхжил 2.9 дахин нэмэгджээ.
- 2013 онд Өмнөговь аймгийн төв Даланзадгад сумын 1,000 хүн амд үйл ажиллагаа явуулж байгаа 19 ААНБ ногдож байсан бол 2024 онд энэ үзүүлэлт 43 болж, бизнесийн идэвхжил 2.3 дахин нэмэгджээ.

**Өмнөговь аймгийн Даланзадгад, Ханбогд сумдын 1,000 хүнд ногдох үйл ажиллагаа явуулж байгаа ААН-ийн тоо**




**Бизнесийн идэвхжил буюу 1,000 хүнд ногдох үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоогоор тэргүүлж буй сум, дүүргүүд, 2024 он**




- Монгол Улсын 330 сум болон нийслэлийн 9 дүүргийг бизнесийн идэвхжил буюу 1,000 хүнд ногдох үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоогоор эрэмбэлэхэд Өмнөговь аймгийн Ханбогд, Даланзадгад сумд хүн ам, бизнесийн нягтрал өндөртэй нийслэлийн Сүхбаатар, Баянгол, Чингэлтэй, Хан-Уул дүүргийн дараа 5 болон 6 дугаар байранд эрэмбэлэгдэж байна.
- Эдгээр сумд бизнесийн идэвхжилийн үзүүлэлт нийслэлийн Баянзүрх дүүргийнхээс 2 нэгжээр өндөр байна.
- Оюу толгой төслийн нөлөөллийн бүсэд хамаарах Өмнөговь аймгийн Баян-Овоо сум 2024 онд бизнесийн идэвхжилийн үзүүлэлтээр Монгол Улсын 330 сум, 9 дүүргээс 17 дугаар, Өмнөговь аймгийн Манлай сум 73 дугаар байранд тус тус эрэмбэлэгдэж байна.
- Өмнөговь аймгийн Баян-Овоо суманд 2013 онд 1,000 хүнд ногдох үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо 12 байсан бол 2024 онд 27 болж, бизнесийн идэвхжил 2.2 дахин нэмэгджээ.

# 02

## Монгол Улсын нэгдсэн төсөвт
## Оюу толгой ХХК-ийн оруулж буй хувь нэмэр

ISO 20252 CERTIFIED RESEARCH STANDARD
ESOMAR 25 Corporate

# Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогод Оюу толгой ХХК-ийн оруулсан хувь нэмэр

### Монгол Улсын нэгдсэн төсөвт Оюу толгой ХХК-ийн оруулсан хувь нэмэр

2010-2024 оны хооронд
**15**
жилийн хугацаанд

Улсын нэгдсэн төсөвт
**10.9**
их наяд төгрөг

Улсын нэгдсэн төсвийн орлогын
**6.6%**
хувийг бүрдүүлжээ

### Монгол Улсын нэгдсэн төсөвт Оюу толгой ХХК-ийн оруулсан орлогын бүтэц

| | | |
|---|---|---|
| Улсын төсөвт | 8.8 их наяд төгрөг | Улсын төсвийн орлогын 6.4% |
| Өмнөговь аймгийн төсөвт | 1.1 их наяд төгрөг | Өмнөговь аймгийн төсвийн орлогын 21.9% |
| Нийгмийн даатгалын санд | 934.6 тэрбум төгрөг | Нийгмийн даатгалын сангийн орлогын 3.1% |
| Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд | 30.9 тэрбум төгрөг | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогын 5.6% |

# Улсын нэгдсэн төсвийн орлогод Оюу толгой ХХК-ийн оруулсан орлогын эзлэх хувь

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын дунд Оюу толгой ХХК-ийн оруулсан орлогын эзлэх хувь




Сэргэлт ба "түүхий эдийн цикл"-ийн өсөлтийн үе

Уналт/саарлалт ба орлогын эмзэг байдал үүссэн үе

Макро тогтворжуулалт, төсвийн сахилга батыг хангах ОУВС-гийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр

Ковид-19-ийн шок, түүнийг сөрсөн төсвийн дэмжлэг

Төсвийн орлогын огцом тэлэлт – түүхий эдийн өсөлтийн эффект

Өмнөговь аймгийн орон нутгийн төсвийн орлогод Оюу толгой ХХК-ийн оруулсан орлогын эзлэх хувь



# Монгол Улсын нэг хүнд ногдох төсвийн орлого

Улсын төсвөөр дамжуулан Оюу толгой ХХК 2010 онд Монгол Улс иргэн бүрд 24,300 төгрөгийг зарцуулж байжээ. Оюу толгой ХХК-ийн 2024 оны улсын төсөвт оруулсан орлогыг Монгол Улсын нийт хүн амын тоонд хуваавал 503.4 мянган төгрөг ногдож байна. Энэ хэмжээгээр Оюу толгой ХХК Монгол Улсын төсвөөр дамжуулан иргэдэд нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын болон аюулгүй байдлыг хангах үйлчилгээг төрөөс хүргэхэд хувь нэмрээ оруулж байна.

**Монгол Улсын нэг хүнд ногдох Оюу толгой ХХК-ийн оруулсан төсвийн орлого, мянган төгрөг**



# Оюу толгой ХХК-ийн улс, орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр, хураамжийн бүтэц

**Оюу толгой ХХК-ийн 2010-2024 оны хооронд улсын төсөвт төлсөн татвар, төлбөр, хураамжийн хэмжээ болон нийт дүнд эзлэх хувь, тэрбум төгрөг, %**




**Оюу толгой ХХК-ийн Өмнөговь аймгийн орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр, хураамжийн хэмжээ болон нийт дүнд эзлэх хувь, тэрбум төгрөг, %**




Товчилсон үгийн тайлбар
- НӨАТ – Нэмэгдсэн өртгийн албан татвар
- АМНАТ – ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
- ХХОАТ – Хувь хүний орлогын албан татвар
- ААНОАТ – Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар

** Тайлбар: Оюу толгой ХХК нь НӨАТ-ын буцаан авалт хийдэггүй тул бүхэлдээ татварын зардал болдог байна.*

# Нийгмийн даатгалын сангийн орлогод оруулсан хувь нэмэр

Сүүлийн 15 жилийн хугацаанд (2010-2024 оны хооронд) Оюу толгой ХХК-ийн ажиллагчдын тоо нийгмийн даатгалд даатгуулагчдын нийт тоонд 0.1-0.4%-ийг эзэлж байсан хэдий ч Оюу толгой ХХК-ийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл нийгмийн даатгалын сангийн орлогын 0.5-4.4%-ийг бүрдүүлж байжээ. Энэ нь Оюу толгой ХХК нийгмийн даатгалын хуваарилалтын буюу эв санааны (Pay As You Go - PAYG) тогтолцоонд гол хувь нэмрийг оруулагчдын нэг гэдгийг харуулж байна.

Нийгмийн даатгалын сангийн орлого болон нийт нийгмийн даатгалд даатгуулагчдын тоонд Оюу толгой ХХК-ийн эзлэх хувь



# Нийгмийн даатгалын сангийн орлогод оруулсан хувь нэмэр

Оюу толгой ХХК-ийн нэг ажилтны төлсөн сарын дундаж нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээ улсын дунджаас 4.3–14.9 дахин өндөр байна. Энэ нь Оюу толгой ХХК нийгмийн даатгалын системийг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэж, дундаж аж ахуйн нэгж, нийгмийн даатгалд даатгуулагчдаас илүүтэйгээр хувь нэмэр оруулж, нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тогтвортой байдлыг хангахад хувь нэмрээ оруулж байгааг харуулж байна.

**Нэг даатгуулагчийн сард төлсөн дундаж НДШ болон Оюу толгой ХХК-ийн нэг ажилтны сард төлсөн дундаж нийгмийн даатгалын шимтгэл, мянган төгрөг**




**1 ажилтан**

Oyu Tolgoi

2024 оны байдлаар Оюу толгой ХХК-ийн 1 ажилтан НДШ-д сард дунджаар 2,772.5 мянган төгрөг төлжээ.

**1 даатгуулагч**

2024 оны байдлаар нэг даатгуулагч НДШ-д сард дунджаар 411.2 мянган төгрөг төлжээ.

**1 ажилтан**

2024 оны байдлаар

**6.7**

дахин их шимтгэл төлсөн байна.

# Нийгмийн даатгалын сангийн орлогод оруулсан хувь нэмэр

Оюу толгой ХХК-ийн ажиллагчдын нийгмийн хамгааллын тогтолцоонд оруулж буй хувь нэмрийн үржүүлэгчийн нөлөө

| Оюу толгой ХХК-ийн ажилчдын төлсөн НДШ | Дундаж тэтгэврийн хэмжээ | Оюу Толгой ХХК-ийн 1 ажилтан хэдэн хүний тэтгэврийг бүрдүүлж байна вэ? |
|---|---|---|
| 2016 оны дунджаар 1,127,700₮ | 2016 оны дунджаар 313,000₮ | 2016 оны байдлаар 3.6 |
| 2024 оны дунджаар 2,772,500₮ | 2024 оны дунджаар 785,600₮ | 2024 оны байдлаар 3.5 |

Оюу толгой ХХК-ийн **4,674 ажилтан**

2024 ОНЫ БАЙДЛААР САРД

**13.0 тэрбум₮**

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ

**16,495 өндөр настны** тэтгэврийг бүрдүүлж байна.

- Оюу толгой ХХК 2024 оны байдлаар сард дунджаар 13.0 тэрбум төгрөгийн НДШ-ийг төлсөн бөгөөд тус **компанийн 4,674 ажилчин нийлээд сар бүр 16,495 ахмад настны тэтгэврийн санхүүжилтийг хангах хэмжээний нийгмийн даатгалын шимтгэл** төлжээ.
- Энэ нь компанийн ажилчдын нийгмийн хамгааллын үйл ажиллагаанд оруулсан хувь нэмрийн үржүүлэгчийн нөлөөг харуулж байна.

# Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогод үзүүлсэн нөлөө

Оюу толгой ХХК-ийн төлсөн гадаадын иргэнийг гэрээгээр ажиллуулсан ажил олгогчийн төлөх ажлын байрны төлбөр, сая төгрөг




**Оюу толгой ХХК-ийн төлсөн гадаад ажилтны ажлын байрны төлбөр**



2010-2024 онд

**30.9**

тэрбум төгрөг

**Ажиллагчдын сарын дундаж цалин (УСХ)**



2024 онд

**2,332.4**

мянган төгрөг

**Нэг ажиллагчийг нэг жил ажиллуулах дундаж зардал**



2024 онд

**28.0**

сая төгрөг

**Оюу толгой ХХК-ийн төлсөн гадаад ажилтны ажлын байрны төлбөрөөр**

**1,104**

ажлын байрыг хадгалахад дэмжлэг үзүүлжээ.



Эсвэл

**Оюу толгой ХХК-ийн төлсөн гадаад ажилтны ажлын байрны төлбөрөөр**

**56,157**

хүнийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр / арга хэмжээнд хамруулжээ.



Эх сурвалж: НҮБХХ-ийн "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн агуулга, үр дүнгийн үнэлгээ" тайлангийн мэдээллийг ашиглан тооцов.

# Ижил төстэй ААН-үүдийн татварын орлого бүрдүүлэлтийн харьцуулалт

ОҮИТБСТ-гаар улсын төсөвт 100 тэрбум төгрөгөөс дээш орлого төвлөрүүлсэн ААН-үүдийн мэдээлэл

## 2023 он

**11** ААН
**125** нийт ААН

**7,345.6** тэрбум төгрөг
**89.1%** нийт орлогын

| Байр | Компани | Дүн | Хувь |
|---|---|---|---|
| #1 | Эрдэнэс Тавантолгой ЕТТ | 2,854.9 тб.₮ | 34.6% |
| #2 | | 1,941.3 тб.₮ | 23.5% |
| #3 | Оюу Толгой | 734.9 тб.₮ | 8.9% |
| #4 | Энержи Ресурс ХХК | 414.2 тб.₮ | 5.0% |
| #5 | МАК Монголын Алт (МАК) ХХК | 336.8 тб.₮ | 4.1% |
| #6 | Khuren Tolgoi Coal Mining | 289.7 тб.₮ | 3.5% |
| #7 | Саусгоби Сэндс SouthGobi Sands | 256.86 тб.₮ | 3.1% |
| #8 | Usukh Zoos | 169.3 тб.₮ | 2.1% |
| #9 | MEC | 121.9 тб.₮ | 1.5% |
| #10 | Тавантолгой ХК | 113.6 тб.₮ | 1.4% |
| #11 | COAL Си Өу Эй Эл ХХК | 112.1 тб.₮ | 1.4% |

## 2024 он

**10** ААН
**110** нийт ААН

**8,164.3** тэрбум төгрөг
**90.0%** нийт орлогын

| Байр | Компани | Дүн | Хувь |
|---|---|---|---|
| #1 | Эрдэнэс Тавантолгой ЕТТ | 3,376.4 тб.₮ | 37% |
| #2 | | 1,464.2 тб.₮ | 16% |
| #3 | Оюу Толгой | 826.8 тб.₮ | 9% |
| #4 | Энержи Ресурс ХХК | 640.4 тб.₮ | 7% |
| #5 | МАК Монголын Алт (МАК) ХХК | 563.1 тб.₮ | 6% |
| #6 | Тавантолгой ХК | 523.2 тб.₮ | 6% |
| #7 | Саусгоби Сэндс SouthGobi Sands | 265.6 тб.₮ | 3% |
| #8 | PetroChina | 214.7 тб.₮ | 2% |
| #9 | Usukh Zoos | 188.1 тб.₮ | 2% |
| #10 | Boroo Gold | 101.6 тб.₮ | 1% |

Эх сурвалж: Монголын олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачилгын тайлан https://www.eitimongolia.mn/

# Ижил төстэй ААН-үүдийн татварын орлого бүрдүүлэлтийн харьцуулалт

- Оюутолгой ХХК 2022 оноос эхлэн Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулж буй "ТОП-100 аж ахуйн нэгж"-ийг үнэлдэг 5 гол үзүүлэлтийн 4-т нь, түүн дотроо төлсөн татварын дүнгээр тэргүүлж иржээ.

**Монгол Улсын 2024 оны ТОП 100 ААН-ийг тэргүүлэгчид**

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| Оюутолгой ХХК | Энержи Ресурс ХХК | Монголын Алт МАК ХХК | ХААН Банк ХК | Голомт банк ХК | Худалдаа Хөгжлийн Банк ХК |
| 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| Премиум нэксүс ХК | НИК ХХК | АПУ ХК | Саусгоби Сэндс ХХК | Мобиком Корпораци ХХК | ХасБанк ХК |

Эх сурвалж: Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим

- Оюутолгой ХХК АМНАТ-т 428.1 тэрбум төгрөг төлж, энэ төрлийн төлбөр төлөлтөөр Эрдэнэс Тавантолгой ХК, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын дараа гуравдугаар байрт орж байна.

**АМНАТ** — **3,824.0 тэрбум төгрөг 42.2% нийт орлогын**




Эх сурвалж: Монголын олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачилгын тайлан https://www.eitimongolia.mn/

# Ижил төстэй ААН-үүдийн татварын орлого бүрдүүлэлтийн харьцуулалт

**Гол орлогын төрлөөр улсын төсөвт 2024 онд хамгийн их орлого оруулсан ТОП 5 аж ахуйн нэгж:**

- Оюутолгой ХХК НДШ-д 155.5 тэрбум төгрөг, НӨАТ-д 111.6 тэрбум төгрөг, ХХОАТ-д 106.6 тэрбум төгрөг төлж, энэ төрлийн шимтгэл, татвар төлөлтөөр тэргүүлжээ.

**НДШ** 546.5 тэрбум төгрөг 6.0% нийт орлогын

**374.0 тэрбум төгрөг**
**68% НДШ-ийн**




**НӨАТ** 310.6 тэрбум төгрөг 3.4% нийт орлогын

**220.2 тэрбум төгрөг**
**71% НӨАТ-ын**




**ХХОАТ** 253.2 тэрбум төгрөг 3.0% нийт орлогын

**201.1 тэрбум төгрөг**
**79.4% ХХОАТ-ын**




Эх сурвалж: Монголын олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачилгын тайлан https://www.eitimongolia.mn/

# 03

## Монгол Улсын нийгэмд Оюу толгой ХХК-ийн оруулж буй хувь нэмэр

ISO 20252 CERTIFIED RESEARCH STANDARD
ESOMAR 25 Corporate

# Монгол Улсын хөдөлмөр эрхлэлтэд үзүүлсэн нөлөө

**“2024 онд нийт 23,110 гаруй ажлын байрыг** шууд, шууд бус болон өдөөгдсөн нөлөөгөөр бий болгожээ.”

Оюу толгой ХХК-ийн шууд болон үржүүлэгчийн нөлөөгөөр бий болсон ажлын байрны тоо, мянган хүн




Шууд бий болгосон ажлын байрны тоо нь **Монгол Улсын нийт ажиллагчдын дунджаар 0.3 хувийг эзэлж байгаа бөгөөд жилийн дундаж өсөлтийн хувь (CAGR) 7.2% байна.**

2015–2024 онд Оюу Толгой ХХК-ийн ажиллах хүчний эзлэх хувь 0.22%-аас 0.34% болж өссөн байна. Энэхүү өсөлт нь компанийн үйл ажиллагаа үндэсний хөдөлмөр эрхлэлтэд үзүүлэх нөлөө нэмэгдэж, эдийн засгийн оролцоо өргөжиж байгааг харуулж байна.

Монгол Улсын нийт ажиллагчдын тоонд Оюу толгой ХХК-ийн бий болгосон нийт ажлын байрны эзлэх хувь



# Ажлын байрны үржүүлэгчийн нөлөө: 2024 онд




**Оюу толгой ХХК-ийн ажлын байрны шууд бус үржүүлэгч 1.601 болж нэмэгдсэн нь:**

Хангамжийн сүлжээн дэх дотоодын үйлдвэрлэгчдийн хувийн жин нэмэгдэх байгаатай холбоотой.

**Оюу толгой ХХК-ийн ажлын байрны өдөөгдсөн нөлөө 2.343 байгаа нь:**

1. Үйлдвэрийн ажилчдын цалингаас үүдэлтэй өрхийн зарцуулалтын эдийн засгийн нөлөөг тодорхой харуулж байна.
2. Үйлдвэрийн нэг ажилчны цалингийн нөлөөгөөр Өмнөговь болон бусад аймгуудад, Улаанбаатар хотод нэмээд 1-2 ажлын байр бий болж байна.

**Оюу толгой ХХК-ийн ажлын байрны нийт үржүүлэгч 4.944 байгаа нь:**

1. Оюу толгой ХХК-ийн үйл ажиллагааны нөлөөгөөр нэмээд 3-4 ажлын байр эдийн засагт бий болжээ.
2. Оюу толгой ХХК-ийн нөлөөгөөр нийт 23.1 мянган ажлын байр бий болсон нь Монгол Улсын нийт ажиллах хүчний 1.7%-ийг эзэлж байна.

**Өдөөгдсөн үржүүлэгчийн нөлөө:**

Ажилчид, ханган нийлүүлэгчдийн орлогоос үүдэлтэй, дотоодын эдийн засагт бий болсон ажлын байр.

**Шууд бус үржүүлэгчийн нөлөө:**

Нийлүүлэлтийн сүлжээний хүрээнд бий болсон нийлүүлэгчид, тээвэрлэгч, туслан гүйцэтгэгчдийн ажлын байр.

**Шууд үржүүлэгчийн нөлөө:**

Компанийн үйл ажиллагаатай шууд холбоотой ажлын байр буюу Оюу толгой ХХК-ийн ажиллагчид

## Давлагаалсан нөлөө (RIPPLE EFFECT)

### Улс орнуудын уул уурхайн салбарын ажлын байрны үржүүлэгч

| | Монгол* | Канад** |
|---|---|---|
| Шууд нөлөө | 1.000= | 1.000= |
| Шууд бус нөлөө | 1.368↘ | 1.339↘ |
| Өдөөгдсөн нөлөө | 0.678↘ | 1.419↘ |
| Нийт нөлөө | 3.045↘ | 3.758↘ |

Тайлбар: ↗ Оюу толгой компанийн үзүүлэлтээс их,
↘ Оюу толгой компанийн үзүүлэлтээс бага,
= Оюу толгой компанийн үзүүлэлттэй тэнцүү.

**Үржүүлэгчийн нийт нөлөө:**

Шууд + шууд бус + өдөөгдсөн

Эх сурвалж: * Салбар хоорондын тэнцэл, ҮСХ, 2019 он,
** Канадын статистикийн газар 2022 он, https://www150.statcan.gc.ca/

# Үндэсний хөдөлмөрийн бүтээмжид Оюу толгой ХХК-ийн үзүүлж буй нөлөө

**Нэг ажиллагчид ногдох ДНБ буюу үндэсний хөдөлмөрийн бүтээмж болон Оюу толгой ХХК-ийн нэг ажиллагчид ногдох нэмэгдэл өртөг, 2015 оны зэрэгцүүлэх үнээр, сая төгрөг**




Нэг ажиллагчид ногдох ДНБ буюу үндэсний хөдөлмөрийн бүтээмж 2010 онд 2015 оны зэрэгцүүлэх үнээр 13.6 сая төгрөг байсан бол Оюу толгой ХХК-ийн нэг ажиллагчид ногдох нэмүү үнэ цэн буюу ажиллагчдын хөдөлмөрийн бүтээмж 1.4 тэрбум төгрөг байсан нь үндэсний хөдөлмөрийн бүтээмжээс 103 дахин өндөр байжээ. **Оюу толгой ХХК-ийн хөдөлмөрийн бүтээмж 2020-2024 оны хооронд үндэсний хөдөлмөрийн бүтээмжээс 5.2-41.3 дахин өндөр байжээ.**

# Үндэсний хөдөлмөрийн бүтээмжид Оюу толгой ХХК-ийн үзүүлж буй нөлөө

- Үндэсний хөдөлмөрийн бүтээмж буюу нэг ажиллагчид ногдох ДНБ 2015 оны зэрэгцүүлэх үнээр 2024 онд 23.6 сая төгрөг байсан бөгөөд Оюу толгой ХХК ороогүй байдлаар тооцвол 23.1 сая төгрөг болохоор байжээ.
- Оюу толгой ХХК 2010-2024 оны хооронд үндэсний хөдөлмөрийн бүтээмжийг 533 мянган төгрөг (хамгийн багадаа 2024 онд) - 5.2 (хамгийн ихдээ 2022 онд) сая төгрөгөөр нэмэгдүүлсэн эерэг нөлөөг үзүүлжээ.

**Нэг ажиллагчид ногдох ДНБ буюу үндэсний хөдөлмөрийн бүтээмж, Оюу толгой ХХК орсон болон ороогүй байдлаар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр, сая төгрөг**



# Уул уурхайн салбарын хөдөлмөрийн бүтээмжид Оюу толгой ХХК-ийн үзүүлж буй нөлөө

Уул уурхайн салбарын нэг ажиллагчид ногдох ДНБ буюу салбарын хөдөлмөрийн бүтээмж, Оюу толгой ХХК орсон болон ороогүй байдлаар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр, сая төгрөг




- Уул уурхайн салбарын нэг ажиллагчид ногдох ДНБ буюу салбарын хөдөлмөрийн бүтээмж 2010–2016 оны хооронд харьцангуй өндөр өсөлттэй байсан бөгөөд энэ хугацаанд Оюу толгой ХХК-ийн бий болгосон нэмүү цэн мөн мэдэгдэхүйц өссөн байна. Тухайлбал, уул уурхайн салбарын хөдөлмөрийн бүтээмжид Оюу толгой ХХК 2014 онд 40.0 сая төгрөгийн эерэг нөлөө үзүүлж байсан бол уг нөлөө 2016 онд 127.3 сая төгрөг болж огцом нэмэгдсэн нь салбарын нийт бүтээмжийн өсөлтөд чухал хувь нэмэр оруулсныг харуулж байна.
- 2024 оны байдлаар уул уурхайн салбарын нэг ажиллагчид ногдох ДНБ 55.4 сая төгрөг байгаа бөгөөд үүнээс Оюу толгой ХХК-ийн нөлөө 9.0 сая төгрөг буюу салбарын нийт хөдөлмөрийн бүтээмжийн 16%-ийг бүрдүүлж байна.

# Монгол Улсын ажиллагчдын цалингийн орлогод Оюу толгой ХХК-ийн оруулсан хувь нэмэр

- 2015-2024 онд Оюу толгой ХХК-ийн нөлөөгөөр эдийн засагт бий болсон нийт цалингийн орлого **227.2 тэрбум төгрөгөөс 2,912.3 тэрбум төгрөг болж нэмэгджээ.**
- Оюу толгой ХХК-ийн цалингийн үржүүлэгч 2015 онд 1.5 байсан бол **2024 онд 4.0 болж нэмэгджээ.**

Оюу толгой ХХК-ийн цалин болон түүний нөлөөгөөр бий болсон нийт цалингийн орлого, тэрбум төгрөг




ДНБ-ий орлогын аргаар тооцсон цалин, түүнтэй адилтгах орлогод Оюу толгой ХХК-ийн цалин, түүний нөлөөгөөр бий болсон цалингийн орлогын эзлэх хувь




**2024 онд ДНБ дэх цалин, түүнтэй адилтгах орлогын хэмжээ**

**3.1%** ← Цалингийн орлогын шууд нөлөөгөөр

**12.6%** ← Цалингийн орлогын нийт нөлөөгөөр

Oyu Tolgoi

# Цалингийн үржүүлэгчийн нөлөө: 2024 онд

### Цалингийн шууд бус үржүүлэгч 1.416 байгаа нь:

1. Компанийн нийлүүлэлтийн сүлжээнд олгогдож буй 1 төгрөгийн цалин нийт эдийн засагт 1.416 төгрөгийн орлогын нөлөө үүсгэж байна гэсэн үг юм.
2. Оюу толгой компанийн нийлүүлэлтийн сүлжээ эдийн засгийн бусад салбаруудтай нягт уялдаатай,
3. Нийлүүлэгчдийн үйл ажиллагаа, ажлын байр нь компанийн үйл ажиллагаатай ихээхэн хамааралтай байгааг харуулж байна.

### Оюу толгой ХХК-ийн цалингийн өдөөгдсөн нөлөө 1.616 байгаа нь:

1. Компанийн олгосон 1 төгрөгийн цалин эдийн засагт нийтдээ 1.616 төгрөгийн орлого бий болгож байгаа
2. Цалин өрхийн хэрэглээг дэмжиж байгаа
3. Хэрэглээ дотоодын салбаруудад орлого бий болгож байгаа
4. Дотоодын эрэлт тогтвортой байгаа
5. Үржүүлэгчийн нөлөө сул биш, бодит байгааг харуулж байна.

### Оюу толгой ХХК-ийн цалингийн нийт нөлөө:

Үйлдвэрийн нөлөөгөөр нийт 2,912.3 тэрбум төгрөгийн цалингийн орлогыг бий болгосон нь Монгол Улсын нийт цалингийн орлогын 12.6%-ийг эзэлж байна.




**Өдөөгдсөн үржүүлэгчийн нөлөө:**
Ажилчид, ханган нийлүүлэгчдийн орлогоос үүдэлтэй, дотоодын эдийн засагт бий болсон нэмэлт цалин.

**Шууд бус үржүүлэгчийн нөлөө:**
Нийлүүлэлтийн сүлжээний хүрээнд бий болсон нийлүүлэгчид, тээвэрлэгч, туслан гүйцэтгэгчдийн ажиллагсдын цалин.

**Шууд үржүүлэгчийн нөлөө:**
Оюу толгой ХХК-ийн ажиллагсдын цалин

## Давлагаалсан нөлөө (RIPPLE EFFECT)

### Монгол Улс уул уурхайн салбарын цалингийн үржүүлэгч

| | Монгол* | Канад** |
|---|---|---|
| Шууд нөлөө | 1.000= | 1.000= |
| Шууд бус нөлөө | 0.230↘ | 0.764↘ |
| Өдөөгдсөн нөлөө | 0.823↘ | 0.099↘ |
| Нийт нөлөө | 2.053↘ | 1.863↘ |

Тайлбар: ↗ Оюу толгой компанийн үзүүлэлтээс их,
↘ Оюу толгой компанийн үзүүлэлтээс бага,
= Оюу толгой компанийн үзүүлэлттэй тэнцүү.

**Үржүүлэгчийн нийт нөлөө:**
Шууд + шууд бус + өдөөгдсөн

Эх сурвалж: * Салбар хоорондын тэнцэл, ҮСХ, 2019 он,

# Монгол Улсын ажиллагчдын сарын дундаж цалинд Оюу Толгой ХХК-ийн оруулсан хувь нэмэр

Монгол Улсын ажиллагчдын сарын дундаж цалин, түүнтэй адилтгах орлого, Оюу толгой ХХК орсон болон ороогүй дүнгээр, тэдгээрийн зөрүү, мянган төгрөг




## 2024 онд

| 1,372.4 мянган төгрөг | + | 44.4 мянган төгрөг | = | 1,416.7 мянган төгрөг |
|---|---|---|---|---|
